

Онцгой тохиолдолд УИХ-ын гишүүдийн ирц өндөр байдаг ёсоор энэ өдөр 71

спикер хэлжээ. Тиймээс “Цөөнхийн үгийг сонсдоггүй УИХ-ын чуулганд суухгүй” хэмээн шийдсэн байна. Чуулганы нээлтэд

бүртгэхгүй байх боломжгүй.

ТҮҮЧЭЭ

Монголын ардчиллын хувь заяа бүрхэг байна

Э.ТӨР

Ингэж дүгнэж болох аж. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “Мянганы хөгжлийн зорилт-9” (МХЗ-9) төсөл, МСНЭ хамтран сэтгүүлчдэд төслийн талаарх сургалт-танилцуулгыг өчигдөр зохион байгуулсан юм.

“МХЗ-9” төслийнхөн Монголын ардчилсан засаглалын төлөв байдлын талаар үе шаттай судалгааны ажил явуулдаг юм байна. 2005 онд Монгол Улс авлигын хэмжүүрээр дэлхийд 85 дугаарт жагсаж байжээ. Гэтэл өнгөрсөн онд 116 руу ухарсан байх юм. Ардчилсан засаглалын төлөвшлийг 10 хүртэл оноогоор дүгнэдэг. Тэгвэл монголчуудын хүссэн хэмжээнд ардчилал хөгжиж чадаагүй бололтой. Эрх мэдлийн төлөөх тэмцэл, авлига хээл хахууль

ардчиллын хөгжилд аюул учруулж байна гэж судалгаанд оролцогчдын олонх үзжээ. Судалгаа нэлээн өргөн хүрээг хамарсан юм. 1992 онд монголчуудын 95.6 хувь нь УИХ-ын сонгуульд оролцож байсан бол 2008 онд 76.5 хувь болж буурсан байна. Сонгуульд оролцоогүй гурван хүн тутмын нэг нь сонгууль нударга бус болдог учраас саналаа өгөөгүй гэсэн тайлбар хэлжээ. НҮБХХ-өөс Монголын ардчилал, ардчилсан засаглалын талаарх судалгааг 2005, 2008, 2010 онд хийхэд ерөнхий төлөв байдал 3.01 оноо буюу ардчилсан ба ардчилсан бус шинж ойролцоо гарсан байна. Ардчилсан засаглалын үнэлгээг 1-5 хүртэлх тоогоор гаргаж болдог аж. Нэг оноотой бол хамгийн ардчилсан бус. Ардчиллаас үлэмж ухарсан, ардчиллын эсрэг шинж гэж үздэг бол хоёр оноо нь ардчилсан бус шинж давамгайлсаныг

илтгэдэг гэнэ. 2010 оны судалгаагаар Монгол Улс 3.01 оноотой байна. 4-5 оноо авахаараа ардчилсан шинж зонхилж байгаа боловч бүрэн баталгаажаагүй, ардчилсан шинж илэрхий болсон, ардчилал бүрэн баталгаажсан улс гэж үздэг юм байна.

“Төр, нийгмийн амьдралд улс төр, бизнесийн бүлэглэлийн гүйцэтгэх үүрэг, үзүүлэх нөлөө нэмэгдэх хандлагатай боллоо. Хөгжлийн томоохон төслүүдийн ажил эхэлж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд улс орны эдийн засгийн тусгаар тогтнол, аюулгүй байдлыг хангах асуудалд онцгой анхаарах шаардлага хурцаар тавигдаж байна. Түүнд нь бодлогын алдаа, намуудын төлөвшил, сонгуулийн үйл явц тодорхой хэмжээгээр нөлөөлжээ” гэж НҮБХХ-өөс гаргасан судалгааны товхимолд өгүүлжээ.

ТУСА

ХОГ
ДЫ
БАТ
ЛАГ
ГҮЙ
ТЕН
ҮЙЛ
ХОЛ
БИ:
ША
ДОС
АНШ
ДАГ
ХОГ
БҮС
БАГ
ТУЛ
БИ:
НЬ
БИ:
МЭ
НЭГ

ЭӨДӨР	Үүсгэн байгуулагч Цэрэндоржийн Балдорж			
	<p>Ерөнхий эрхлэгч Балдоржийн Нандинтүшиг</p> <p>Нэгдүгээр орлогч эрхлэгч</p>	<p>Орлогч эрхлэгч Ш.Даваадорж 98116881 99993595</p> <p>Тамгын газрын дарга</p>	<p>АЛБАД</p> <p>Улс төрийн мэдээлэл И.Ранчинханд 99233310</p> <p>Шуурхай мэдээлэл Х.Болормиа 99265625</p> <p>Эко мэдээлэл Ц.Цавзанхэрлэн 96001660</p> <p>Эрх зүй, эрэн сурвалжлах</p>	<p>Чөлөөт цаг, танин мэдэхүй Ж.Эрдэнэцэцэг 91175355</p> <p>Гэрэл зураг Г.Эрдэнэтуяа 99164755</p> <p>Амралтын дугаар “Ням гариг” Ш.Даваадорж 98116881</p> <p>ММ сурвалжын төв</p>